


 БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГА ДӨРДӨНЭЖАРГАЛ

**АЛТАЙ СУМД НИЙГИЙН ЭЗЭМШЛИЙН БИЕ ЗАСАХ БАЙГУУЛАМЖ БАРИХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

Алтай сум

№	Хийгдэх ажлын нэр	Тавигдах шаардлага
1	Нийтийн бие засах байгууламж	Алтай сумын төвд нийтийн эзэмшлийн талбайд бие засах байгууламж барих /зөөврийн/
2	Байршил	Сумын төвд
3	Захиалагч байгууллага	Алтай сумын Засаг даргын Тамгын газар
4	Санхүүжилт	Сумын ОНХС
Ерөнхий шаардлага		
5	Ариун цэврийн байгууламжинд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир усны шугам хоолойн байрлал болон угсралт нь БНББ40-06-16 “ Дотор сантехникийн систем”-ийн шаардлагад нийцсэн байна. - Бие засах суултуурын өрөө, гар угаах өрөөний ханыг /доторлогоог/ ус чийгэнд тэсвэртэй материалаар хийсэн байна. - Дотор талын ус, цахилгааны шугамыг далд хийгээр хийнэ. - Ус зайлуулах хоолойн гарах, шугам хоолойг PVC материалаар хийнэ. - Цэвэр, бохирыг бүрэн шийдвэрлэх - Хаалганы цоож бат бөх, гадна, дотроосоо онгойдог байна. - Ариун цэврийн байгууламжийн барилгын гадна талын хаягыг босоо хэлбэрээр нүдэнд шууд харагдах газар байрлуулна. - Шээлтүүр, суултуурын тусгаарлах хаалт нь бат бөх, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна. - Эрэгтэй, эмэгтэй тусдаа ариун цэврийн өрөөтэй байх ба MNS 6392:2013 /Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага/ 4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага / MNS 4236:2003/ дагуу төлөвлөнө.
Ажлын тоо хэмжээ		
6		<ul style="list-style-type: none"> - Ариун цэврийн байгууламж нь орчин үеийн хийцтэй, боловсон байх ба техникийн өрөө, бие засах өрөө гэсэн үндсэн байгууламжтай байх ба 2 хэсгээс бүрдэнэ. /тасалгаатай/ <p><u>Байгууламжийн гадна хэсэг:</u></p> <ul style="list-style-type: none"> - Бие засах зориулалттай байгууламж нь өвлийн улиралд ашиглаж болохуйц дулаалга, доторлогоотой/хана, тааз, шал гэх мэт/ урт 6м, өргөн 2.4м-ээс багагүй хэмжээтэй тохижуулсан 20 тн-ын контейнер байна. - Контейнерийн гадаргууг ус чийгэнд тэсвэртэй төмрийн будгаар будах ба гадна талын өнгө нь

цагаан саарал өнгөтэй, хүрээг цагаан өнгөөр тус тус будсан байна.

- Цонх нь битүүмжлэл сайтай 0.5м*0.8м хэмжээтэй вакум цонх 2 ширхэг суурилуулна.
- Хаалга бат бөх, дулаалгатай 0.96*2.05 хэмжээтэй хаалга 1 ширхэг байна.

Байгууламжийн дотор хэсэг:

Техникийн болон бие засах өрөө гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Бие засах өрөө буюу үндсэн байгууламж нь:

- Хана, тааз нь дулаалгатай доторлогоо хийх ба цэвэрлэхэд хялбар байна.
- Суултуур, угаалтуур болон түүний дагалдах тоног төхөөрөмж нь бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй байх ба суултуур 3 ширхэг, шээлтүүр 2 ширхэг, угаалтуур 1 ширхэг байна. /суултуур эмэгтэй 2, эрэгтэй 1 тасалгаанд байна./
- Байгууламжийн дотор тасалгааг бат бөх хавтангаар хийх ба хаалганы нээгдэх хэмжээ 0.6м*2м, кабин тус бүр 85см*120см-ээс багагүй байна.

Техникийн өрөө:

- Нөөцийн зориулалттай сав байрлуулах ба 1 тний багтаамжтай байна.
- Сантехникийн шугам хоолойг зохиулалтын PVC хоолойгоор угсарч суурилуулна.
- Ариун цэврийн ус шахах насосыг тухайн байгууламжийн хүчин чадалд тохируулан суурилуулах ба /550Вт-аас багагүй байх/

Нэмэлт тоноглол:

- Толь 1 ширхэг
- Разетка 4 ширхэг /техникийн өрөөнд 2, ариун цэврийн өрөөнд 2/
- Унтраалга 3 ширхэг /техникийн өрөөнд 2, ариун цэврийн өрөөнд 1/
- Гэрэлтүүлэг 4 ширхэг /ариун цэврийн өрөөнд 3, техникийн өрөөнд 1/
- Ариун цэврийн цаас тогтоогч тасалгаа бүрд 1 ширхэг
- Өрөө тус бүрт хогийн савтай байна.
- Өрөө тус бүрт суултуур цэвэрлэгч сойтогтой байна.

Гадна бохирын байгууламж

- Хэрэглэсэн бохирыг цуглуулах савыг байгууламжийн хажууд хөрсөнд нэвчилтгүй соруулах зориулалтаар газар ухаж хийнэ. Бохир цуглуулах сав нь 2тн-оос багагүй хэмжээтэй бат бөх, зохиулалтын дагуу хийгдсэн байна.

		- Орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан байх
7	Хүлээлгэн өгөх хугацаа	Ажлыг 2024 оны сарын -ны өдөрт багтаан хийж, хүлээлгэн өгнө.
8	Багц ажлын үнэ	- 30,000,000 /Гучин сая/ төгрөг/ ба хийж гүйцэтгэх, тээвэр, шатахуун, суурилуулалт, ажиллах хүчний зардал зэрэг багтсан болно.
7	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	- Баталгаа 1 жил - Ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх -

БОЛОВСРУУЛСАН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.БАТБАЯР

